



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IY байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.12.25 № 02/89

Төсвийн орлого болгох тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2013 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Эрүүл хүүхэд аяны санхүүжилт, үр дүн” аудит хийх явцад “Эрүүл хүүхэд” аяны хөрөнгө болох 8,294,000 төгрөгөөр хүлээлгийн сандал, 3,254,169 төгрөгөөр венийн судас ологч, 5,000,000 төгрөгөөр зүрхний бичлэгийн аппарат 2 ширхэг, 7,951,500 төгрөгөөр хөрөнгө бэлтгэж, нийт 24,499,669 (Хорин дөрвөн сая дөрвөн зуун ерөн есөн мянга зургаан зуун жаран есөн) төгрөгийн бараа материал худалдан авч зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т “Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг ... зориулалтын бус чиглэлээр ашиглах, байршуулахыг хориглоно”, Сангийн сайдын 73 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”-ын 8 дугаар зүйлийн 8.1-д “Төсвийн байгууллага нь олгосон санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулахаас өөр бусад хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулахыг хориглоно”, Эрүүл мэндийн сайдын 2012 оны 2/997 дугаар тушаалыг тус тус зөрчсөн байна.

Иймд Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх”, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д “...алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэж заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1. Зориулалт бусаар зарцуулсан 24,499,669 (Хорин дөрвөн сая дөрвөн зуун ерөн есөн мянган зургаан зуун жаран есөн) төгрөгийг 2014 оны 2 дугаар сарын 1-нд багтаан Нийгмийн даатгалын ерөнхий газрын эрүүл мэндийн даатгалын сангийн 900090003 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2014 оны 2 дугаар сарын 10-ны дотор гарган Үндэсний аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг Эх хүүхдийн үндэсний төвийн ерөнхий захирал Ш.Энхтөр, ерөнхий нягтлан бодогч С.Жавзандулам нарт хариуцуулан акт тогтоов.

АКТ



ТОГТООСОН:

АУДИТОР  Д.УРТНАСАН

ТУСЛАХ АУДИТОР  Л.НЯМТӨМӨР

УХА0122

ЗӨВШӨӨРСӨН:

ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЕРӨНХИЙ  
ЗАХИРАЛ  Ш.ЭНХТӨР  
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ  
 С.ЖАВЗАНДУЛАМ

9077588